МЭДЭЭ · 2023 оны 4-р сарын 14

ПРОКУРОР, ШИНЖЭЭЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт судалгааны хүрээлэн, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс хамтран "Прокурор, шүүх шинжилгээний байгууллагын шинжээч нарт зориулсан сургалт, хэлэлцүүлэг"-ийг 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгууллаа.

Шинэчлэн батлагдсан Шүүх шинжилгээний тухай хууль энэ оноос эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор прокурор, шинжээч нарт нэгдсэн ойлголт өгч, практикт хэвшүүлэх зорилготой тус арга хэмжээнд аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газрын прокурорууд, Шүүх шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтнүүд, Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлахуйн институтийн багш, судлаачид зэрэг 500 орчим алба хаагчид танхим болон цахим хэлбэрээр оролцсон байна.




POLICE



Сургалт, хэлэлцүүлэгт оролцогчдод шинэчлэн батлагдсан хуулийн үзэл баримтлал, шинээр орсон өөрчлөлтүүд, шинжээч шүүх хуралдаанд оролцоход анхаарах асуудал зэрэг сэдвээр мэдээлэл өгч, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах түүнд чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч болон прокурорын зүгээс тулгамдаж буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэж, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр санал солилцсон үр дүнтэй арга хэмжээ боллоо.




Шүүх хуралдааны ерөнхий нөхцөл
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар бүлэг.
35.1.Шүүх хуралдааныг нээх
35.2.Орчуулагч, хэлмэрчид түүний үүргийг тайлбарлах
35.3.Гэрчийг шүүх хуралдааны танхимаас гаргах
35.4.Шүүгдэгчид яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулсан, яллах дүгнэлтийн хуулбарыг гардуулан өгсөн эсэхийг шалгах
35.5.Шүүх бүрэлдэхүүнийг зарлах, татгалзан гаргах эрхтэй болохыг тайлбарлах /Шүүгдэгчийн хувьд шинжээчээс татгалзах эсэхийг/
35.6.Шүүх хуралдаанд оролцогчийн эрх үүргийг тайлбарлах
35.7.Шүүхийн хэлэлцүүлэг явуулах дараалал тогтоох
www.prokuror.mn


ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ТАЛААР
• Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Шүүх шинжилгээний тухай хууль дахь прокурор, шинжээч нарын эрх үүрэг, эрх зүйн зохицуулалт;
• Улсын ерөнхий прокурорын 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А36 дугаар тушаалаар батлагдсан "Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах тухай журам"-ын талаар;
• ...амнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц дахь ...илгээний ажиллагаатай холбоотой заалт.
...дах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын нэр томъёо гэх мэт)



Видео: https://www.youtube.com/watch?v=ZGcUywVCMd0

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1829